



I-IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 12




Улсын хэмжээнд 2.4 сая толгой мал хорогдсон байна

Улсын хэмжээнд 2020 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 29.7 сая хээлтэгч малын 20.9 сая (70.5%) нь 2021 оны эхний 9 сард төллөсөн байна.

Эм хонины 77.1 хувь, эм ямааны 64.9 хувь, үнээний 68.1 хувь, гүүний 61.3 хувь, ингэний 35.7 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 95.5 хувь буюу 20.0 сая төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 2.9 (12.6%) саяар буурсан байна

ЗУРАГ 1. ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, хувиар, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Том малын зүй бус хорогдол 2021 оны эхний 9 сард улсын хэмжээнд 2.4 сая болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (78.4 хувь) саяар нэмэгдсэн байна. Харин 2021 оны 7-9 дүгээр сард 18.0 мянган толгой мал хорогдсон нь эхний 9 сард хорогдсон малын 0.7 хувийг эзэлж байна.


Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, ямаа 1.3 сая, хонь 852.3 мянга, үхэр 146.4 мянга, адуу 88.2 мянга, тэмээ 15.0 мянгаар тус тус хорогдсон байна. Нийт хорогдсон малын 54.2 хувийг ямаа, 35.4 хувийг хонь эзэлж байна.

ХҮСНЭГТ 1. ХОРОГДСОН ТОМ МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Малын төрөл	Хорогдсон том мал				Оны эхний малд том малын хорогдлын эзлэх хувь			
	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020 I-IX	2021 I-IX
	мянган толгой				хувь			
Дүн	2 216.5	755.8	1 348.0	2 405.4	3.35	1.14	1.90	3.59
Адуу	137.3	39.1	69.8	88.2	3.49	0.99	1.66	2.16
Үхэр	199.0	50.3	96.4	146.4	4.54	1.15	2.03	3.09
Тэмээ	1.7	1.0	0.8	15.0	0.40	0.22	0.17	3.18
Хонь	762.8	316.8	675.3	852.3	2.53	1.04	2.09	2.84
Ямаа	1 115.5	348.6	505.8	1 303.4	4.08	1.29	1.73	4.70

Хорогдлыг аймгаар нь авч үзэхэд 2021 оны эхний 9 сард Баянхонгор аймагт 744.8 (31.0 хувь) мянга, Дундговь аймагт 373.6 (15.5 хувь) мянга, Өвөрхангай аймагт 277.2 (11.5 хувь) мянга, Говь-Алтай аймагт 252.3 (10.5 хувь) мянган мал хорогдсон нь нийт хорогдлын 68.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 2. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, мянган толгой



Улсын хэмжээнд 2020 оны эцэст тоологдсон 29.7 сая эх малын 652.6 мянга (2.2%) нь 2021 оны эхний 9 сард хорогдсон байна. Төв, Өвөрхангай, Дундговь, Баянхонгор аймагт хээлтэгч мал 52.3-200.8 мянгаар хорогдсон нь нийт хорогдсон хээлтэгчийн 69.8 хувийг эзэлж байна. Харин 18.0 мянган хээлтүүлэгч хорогдсоноос ухна 8.4 мянга, хуц 6.8 мянга, бух 1.8 мянга, азарга 955, ат 33 тус тус байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 9 сард 14.7 мянган мал өвчнөөр хорогдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 22.3 (60.3 хувь) мянгаар буурсан байна. Харин 2021 оны 7-9 дүгээр сард 0.6 мянга хорогдсон нь эхний 9 сард өвчнөөр хорогдсон малын 4.4 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3. ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



Хорогдсон нийт том малын 81.3 хувь нь бусад буюу чоно, баавгай, ирвэс зэрэг зэрлэг амьтанд бариулах, мөсөнд цөмрөх, хад асгаас унах, өлдөх, осгох зэрэг шалтгаанаар хорогдсон бол 18.1 хувь нь аюулт үзэгдлээр, 0.6 хувь нь өвчнөөр хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт

Том малын зүй бус хорогдол

Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь

Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.



Эх үүсвэр

ҮСХ, Том малын зүй бус хорогдлын мэдээ

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2022 оны 1 дүгээр сарын 14

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Э.Болормаа
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212